УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАЯРМАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.10.13 № ХЭГ/3472
танай 2026.09.17 -ны № 60 -т

Хариу хүргүүлэх тухай

Хууль зүй, дотоод хэргийн салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Таны асуулттай танилцлаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 178 дугаартай тушаалаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад үүссэн асуудлыг шуурхай шалгаж, санал, дүгнэлт боловсруулж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд тус Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байгаа талаар албан бичиг ирүүлснийг үүгээр уламжилж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 1/5272 дугаартай албан бичгийг хавсаргав.

Хавсралт 1 хуудастай.

Монгол Улсын Засгийн газар
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Баттөмөр Энхбаяр
2026.10.13 14:51

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 3/4
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26-73-33
Цахим шуудан: info@mojha.gov.mn
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.10.08 № 1/5272

танай 2026.09.23 -ны № ХЭГ/3236 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагаас “Хууль зүй, дотоод хэргийн салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар” Монгол Улсын Ерөнхий сайдад асуулт тавьжээ.

Засгийн газрын 2026 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар Ерөнхий сайдаас өгсөн үүргийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад үүссэн асуудлыг шуурхай шалгаж, санал, дүгнэлт боловсруулж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 178 тоот тушаалаар байгуулж, холбогдох шалгалтын ажиллагааг явуулж байгаа бөгөөд шалгалтын үр дүн эцэслэн гараагүй байна

Иймд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд асуултын хариуг бэлтгэж хүргүүлэх боломжгүй байгааг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаад уламжилж өгнө үү.

Хууль зүй, дотоод хэргийн яам
Удирдлага
Сайд
Ганзориг Тэмүүлэн
2026.10.10 12:37